

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Б.НАРАНТУЯА



ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЛХИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Үндэслэл:

2019 оны 5 дугаар сард Женев хотод болсон Дэлхийн эрүүл мэндийн 72 дугаар чуулганаар “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх Дэлхий нийтийг хамарсан арга хэмжээ авах тухай” WHA 72.6 тогтоолыг баталж, жил бүрийн 9 дүгээр сарын 17-ныг тэмдэглэлт өдөр болгохоор тогтсон. ДЭМБ-ын судалгаагаар эмнэлгийн тусламж үйлчилгээний нийт урьдчилан сэргийлэх боломжтой хохирлын 50%-ийг эмийн хор хөнөөл эзэлж байгаа бөгөөд зохисгүй эмийн эмчилгээ, эмийн алдаа нь дэлхийн хэмжээнд эрүүл мэндийн салбарын урьдчилан сэргийлэх боломжтой хор хохирлын тэргүүлэх шалтгааны нэг болоод байна. Иймд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас энэ жилийн “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал”-ын Дэлхийн өдрийг **“Эмийн аюулгүй байдал- Аюулгүй эмийн эмчилгээ”** гэсэн уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхээр болсон.

Зорилго:

2022 оны үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр нь **“Эмийн аюулгүй байдал- Аюулгүй эмийн эмчилгээ”** гэсэн уриан дор эмтэй холбоотой сэргийлж болохуйц хор хөнөөл, эмийн эмчилгээний алдааг бууруулах замаар эм ашиглах тогтолцоог бэхжүүлэх, эмийн аюулгүй байдлыг сайжруулах зорилготой.

Зорилт:

1. ЭМЯ, ДЭМБ, ЭЭХХЗГ, ЭМХТ, Төрөлжсөн мэргэшлийн төвүүдийн чанарын алба, эм зүйн алба, НЭМГ-ийн холбогдох мэргэжилтнүүдийн уулзалт зохион байгуулах
2. Эмийн аюулгүй байдлын чиглэлээр сурталчилгааны материал болон цахим контентыг бэлтгэх, олон нийтэд түгээх

3. “Аюулгүй эмийн эмчилгээ” сэдэвт танхим болон цахим сургалт зохион байгуулах
4. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр- 2022 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хөшөө, барилга, дурсгалт газрыг улбар шар өнгөөр гэрэлтүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах хүн
1	ЭМЯ, ДЭМБ, ЭЭХХЗГ, ЭМХТ, Төрөлжсөн мэргэшлийн төвүүдийн чанарын алба, эм зүйн алба, НЭМГ-ийн холбогдох мэргэжилтнүүдийн уулзалтын бэлтгэл ажлыг хангах	9 сарын 5-30	ЭМХТ МИА
2	Уулзалт зохион байгуулах		
3	Эмийн аюулгүй байдлын чиглэлээр сурталчилгааны материал болон цахим контентыг бэлтгэх, олон нийтэд түгээх		
4	“Аюулгүй эмийн эмчилгээ” сэдэвт танхимын болон цахим сургалт зохион байгуулах		
5	Хөшөө, барилга, дурсгалт газрыг улбар шар өнгөөр гэрэлтүүлэх		

Санхүүжилт:

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага- 3,170,000 төгрөг

/Нийт 1000 \$, 1 ам.доллар 3170/

Хугацаа:

2022 оны 09 дүгээр сарын 5-30

Үр дүн:

1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдрийг тэмдэгдэглэх хүрээнд оролцогч талуудын уулзалт зохион байгуулагдсан байна.
2. Эмийн аюулгүй байдлын чиглэлээр сурталчилгаа материал болон цахим контент бэлтгэж олон нийтэд түгээсэн байна.
3. Эмийн аюулгүй байдлын чиглэлээр танхимын болон цахим сургалт зохион байгуулагдсан байна.
4. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр- 2022 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хөшөө, барилга, дурсгалт газрыг улбар шар өнгөөр гэрэлтүүлж олон нийтэд сурталчилсан байна.

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Б.НАРАНТУЯА

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЛХИЙН ӨДРИЙГ
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН ТӨСӨВ**

№	Төлөвлөсөн ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ/ төгрөг/	Төсөв/ төгрөг/
Оролцогч талуудын уулзалтын үйл ажиллагааны зардал					
1.	Цайны зардал	хүн*удаа	30 хүн*1 удаа	12,000	360,000
2.	Зохион байгуулагчийн ажлын хөлс	хүн*удаа	2хүн*1удаа	20,000	40,000
Сурталчилгааны материал, цахим контент бэлтгэж, түгээх үйл ажиллагааны зардал					
3.	Эмийн аюулгүй байдал-Хор хөнөөлгүй эм шторк бэлтгэх	сек	50	-	1,200,000
4.	Эмийн аюулгүй байдал-Хор хөнөөлгүй эм шторк түгээх	сек	50	-	570,000
Сургалт зохион байгуулах үйл ажиллагааны зардал					
5.	Цайны зардал	хүн*удаа	50хүн*1удаа	12,000	600,000
6.	Зохион байгуулагчийн ажлын хөлс	хүн*удаа	2хүн*1удаа	20,000	40,000
7.	Багшийн ажлын хөлс	Хүн*цаг	3 хүн*2 цаг	45,000	270,000
8.	Бусад /Харилцаа холбоо, бичиг хэрэг/				90,000
	НИЙТ ТӨСӨВ				3,170,000

Төсвийг хянасан:

Ахлах нягтлан бодогч Б.Очир

Боловсруулсан:

МИА-ны дарга М.Одгэрэл